

Сэлэнгэ сумын Соёлын төвд санхүүгийн хяналт шалгалт  
хийсэн дүнгийн тухай

**НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО**

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 09 сарын 25-ны өдрийн 1/18 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Соёлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа 2017 оны 09 сарын 26-ны өдрөөс ажлын 3 хоногт багтаан шалгалтыг хийв.

**ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Соёлын төвийн 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалт, шатахууны хэтрэлт хэмнэлт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Сэлэнгэ сумын 5-р багт байрлах Соёлын төв нь сумын иргэд албан хаагчдад соёлын үйлчилгээг түгээх үндсэн зорилготой.

Соёлын төвийн даргын 2016 оны 01 дугаар сарын 11-ний өдрийн А/01 дугаар тушаалын 1 дугаар хавсралтаар эрхлэгч, хөгжмийн багш, бүжгийн багш, номын санч, үйлчлэгч нийт 5 орон тоотой ажилласан байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл П.Хонгорзул, 2-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал

М.Энхбат нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040935090 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад байгууллагуудаас шалгалт ороогүй, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул дүгнэлтгүй олгоогүй.

#### ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Соёлын төвийн 2016 оны касс харилцах, цалингийн баримт, эрхлэгчийн тушаал, бараа материалын баримт, 2016 оны санхүүгийн тайлан, 2016 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт зэрэг материалуудад тулгуурлан эрхлэгч П.Хонгорзул, нягтлан бодогчоор ажиллаж байсан М.Энхбат, нярав .....нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2016 онд улсын төсвөөс 50526.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, үйл ажиллагааны орлогоос 1080.5 мянган төгрөг бүгд 51607.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2016 онд төсөвт зардлыг 50526.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсдын цалинд 34480.8 мянган төгрөг, тогтмол зардалд 7128.9 мянган төгрөг, нормативт зардалд 45.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 417.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 300.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 80.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 135.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1108.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэлийн үндсэн 040935090 дугаар данснаас үлдэгдэл 509 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

#### Нэмэлт орлогын талаар:

2016 онд өөрийн үйл ажиллагааны орлогыг 1768.4 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр заалны түрээсийн орлогоос 159.0 мянган төгрөг, өөрсдийн тоглолтын орлогоос 492.0 мянган төгрөг, бусад гадны тоглолтын орлогын шимтгэл 429.5 мянган төгрөг нийт 1080.5 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 619.5 мянган төгрөгөөр тасалсан.

*Цалин урамшууллын талаар:* 2015 оны үр дүнгийн гэрээгээ дүгнүүлж В үнэлүүлсэн тул 0.5 сарын цалингаар урамшуулж 269.9 мянган төгрөг, Соёлын төвийн эрхлэгчийн 2016 оны 03 сарын 18-ны өдрийн А/03 дугаар тушаалаар бүжгийн багш Х.Мөнхцэцэгт бие биелэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг сайн хангаж 65 сурагч хамруулсан тул үндсэн цалингийн 30%-иар ур чадварын нэмэгдэл 134.0 мянган төгрөг, 2016 оны 06 сарын 21-ний өдрийн А/05 дугаар тушаалаар хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж үндсэн цалингийн 40%-иар хөгжмийн багш Т.Баттулгад 192.2 мянган төгрөг, бүжгийн багш Х.Мөнхцэцэгт 178.7 мянган төгрөг, номын санч С.Ганзоригт 183.5 мянган төгрөг, үйлчлэгч Т.Түмэнбаярт 158.7 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 16-ны өдрийн А/09 дугаар тушаалаар жилийн эцсийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж үндсэн цалингийн 20%-иар хөгжмийн багш Т.Баттулгад 288.3 мянган төгрөг, бүжгийн багш Х.Мөнхцэцэгт 275.2 мянган төгрөг, номын санч С.Ганзоригт 275.2 мянган төгрөг, үйлчлэгч Т.Түмэнбаярт 297.6 мянган төгрөгийн тус ур чадвар урамшуулал олгосон байна.

**6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:**

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	178352239			178352239
2	Машин тоног төхөөрөмж	20454503.70			20454503.70
3	Тавилга, эд хогшил	14145510.20			14145510.20
4	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс/	9873361			9873361
	Дүн	222825613.90			222825613.90

2016 онд худалдан авсан болон хандиваар авсан үндсэн хөрөнгө байхгүй.

**6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг		60000	60000	
2	Аж ахуйн материал		1233460	1233460	
3	Түлш шатах тослох		6800000	6800000	
4	Сэлбэг хэрэгсэл		18000	18000	
5	Бусад хангамжийн материал	12781425	1551150		14332575
	НИЙТ ДҮН	12781425	9662610	8111460	

Соёлын үйлчилгээг сайжруулах зорилгоор нийт 1551.1 мянган төгрөгийн 17 нэр төрлийн бүжгийн хувцас, амьтадын баг, дээл хантааз, хөгжим, микрофоны холбогч зэрэг багаж хэрэгсэл гэх мэт материалуудыг худалдан авсан байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2016 онд авлага, өглөггүй тайлан баланс гарсан байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 149 мэдээлэл оруулахаас 2016 онд 97 мэдээллийг хугацаанд нь, 46-ийг хугацаа хоцроож мэдээлсэн, 6 мэдээллийг мэдээлээгүй байна.

#### ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан. Няравын тайлан нь эмх цэгцтэй үдэж архивлагдсан.

#### НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Шатахууны тайлан гаргалт, тооцоо бодолтын байдлыг шалгахад 2016 онд Орхон “НИК” ШТСтандид шатахууны үнэнд 040935090 дугаар бүртгэлийн данснаас 369.7 мянган төгрөгийг шилжүүлж нярав тайланд орлогодож зарлагдсан ч шаардах хуудас бичээгүй, хаашаа хэн юунд явсан жолоочийн тооцооны хуудас бичдэггүй.

2. Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэлт, хөтлөлт шаардлага хангахгүй байна. Тухайлбал: агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтлөөгүй, шаардах хуудас бичдэггүй, зарцуулалтын тайлан гаргаагүй.

3. 2016 онд Өгөөмөр зам ХХК-аас худалдан авсан 80 тонн нүүрсийг хэн хэн байлцаж, хэзээ буулгаж, хүлээлцсэн талаарх үйлдсэн баримт байхгүй, уурын зууханд хэрэглэсэн нүүрсийг авсан хэмжээгээр бөөндүүлж сарын эцэст зарлага болгодог.

4. Хөгжмийн багш Т.Баттулгад 2016 оны 04 сард үндсэн баримтгүй буюу томилолтын хуудасгүйгээр 48.0 мянган төгрөг олгосон, 2016 оны 12 сарын 20-нд 478.0 мянган төгрөгийг Түмэнбаярын дансруу шилжүүлсний 300.0 мянган төгрөг нь сумын шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулах зардал нь байгууллагын даргын тушаалтай, 178.0 мянган төгрөг нь баримтгүй, 2016 оны 10 сарын 27-нд 132.0 мянган төгрөгийн материалын үнийг Л.Хишигдорж, П.Болд-эрдэнэ нарын данс руу үндсэн баримтгүй байсныг шалгалтын явцад баримтыг бүрдүүлсэн..

5. Хагас болон бүтэн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгохдоо ур чадварын нэмэгдэл олгох Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолыг үндэслэж 40, 60 хувиар ур чадварын нэмэгдэл олгосон.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,  
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг шалгалтын явцад 2017 оны няравын 6-9 сарын тайланг шалгаж зарцуулалтын тайланг гаргуулж, шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалт мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна дүгнэлээ.

АРВАН НЭГ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийдэг, зардал гаргадаг явдлыг таслан зогсоож Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах

Шатахууны зардлын гүйцэтгэлд хяналт тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА

